

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

НЭГ. КОМПАНИЙН ТУХАЙ

Тахько (ХК) компани Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдах шийдвэр гарч, Тахько хувьцаат компани (100 хувь хувийн өмчид шилжсэн) байгуулагдсан үеэс өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани 1992 онд буюу хувьчлагдах үеийн эхлэлтийн балансаар 345,567.5 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 592,830 ширхэг энгийн хувьцаатай байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 16,017,089 мянган төгрөгийн хөрөнгөтэй, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг бүр нь 168 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийтэд зарласан чөлөөтэй арилжаалагдах 1,189,983 ширхэг энгийн хувьцаатай нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр ажиллаж байна.

ХОЁР. 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн засаглал

Тахько (ХК) компанийн захиргаа (гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын нэгжийн албадууд) 2020 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Монголын компанийн засаглалын кодекс, стандартын шаардлагыг мөрдөж, засаглалын үйл ажиллагааг ил тод явуулж ажиллаж байна.

Компанийн захиргаа 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2019 оны санхүүгийн тайланд аудит хийлгэсэн PricewaterhouseCoopers аудит компанийн дүгнэлт, Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, уг хурлыг онлайнаар зохион байгуулах, аудитын компани сонгох, компанийн 2020 оны төлөвлөгөө, орлого, зардлын төсөв зэрэг асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан.

Компанийн захиргаа Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, төрийн зохицуулах байгууллагаас баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн хийж,



хүчин төгөлдөр саналын эрхийн 85.8 хувийн ирцтэйгээр хуралдуулж, хурлаар хэлэлцсэн Компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, дотоод ажлын зардлын төсвийг батлах асуудлуудыг хуралд оролцогчдын 63.2-100 хувийн саналын эрхээр тус тус батлуулж шийдвэрлүүлсэн.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, холбогдох бусад баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д хуульд заасан хугацаанд хүргүүлж, хууль тогтоомж, төрийн зохицуулах байгууллагаас гаргасан журам, хугацааны заалтыг хэрэгжүүлж ажилласан.

2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн 6, хараат бус 3 гишүүн сонгогдсон. Сонгогдсон гишүүд өмнө нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан, үүнээс хараат бус гишүүд нь Компанийн хуульд заасан шаардлага, шалгуурыг бүрэн хангаж байгаа бөгөөд сонгогдсон гишүүдийн тухай мэдээллийг Хөрөнгийн биржийн болон компанийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (ТУЗ-ийн 2020.02.18-ны № 01 тогтоол)-ийн дагуу компанийн 2019 оны цэвэр ашгаас 1,189,983 ширхэг энгийн хувьцаанд хуваарилсан 128,518.2 мянган төгрөгийн ногдол ашгаас хувь хүн ба аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 12,309.4 мянган төгрөг суутган харьяалах татварын байгууллагад шилжүүлэн тайлагнаж, 115,981.9 мянган төгрөг (Үүнээс 110,625.5 мянган төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан, 5,356.4 мянган төгрөгийн ногдол ашгийг компани дээр тус тус олгож)-ийн ногдол ашгийг бүртгэлийн өдрөөр ногдол ашиг хүртэх эрхтэй 627 хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдөр байршуулж, хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд тайлагнасан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-20.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан Мэдээллийн ил тод байдлын журмын 1.2-1.3, 2.2, 3.1, 3.3, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн журмын 21.1-21.9, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2020 оны 1/22 тоот хамтран ажиллах бичгийн 1-4, мөн бичгийн хавсралт мэдээллийн хуанлийн 12 заалтыг тус тус хэрэгжүүлж санхүүгийн ба санхүүгийн бус тайлан, хугацаат ба тухай бүр мэдээлэх мэдээллийг хувьцаа эзэмшигч, олон нийт, холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд мэдээлэх үүргийг биелүүлж ажилласан.

Компанийн веб хуудасны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, компанийн бусад мэдээллийг мэдээлж, хувьцаа эзэмшигч болон олон нийтийг мэдээллээр хангах үүргийг биелүүлэн ажиллаж байна.

2020 онд их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй, үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх нөхцөл байдал үүсч бий болоогүй болно.

Компани 2020 онд Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн тогтоол, шийдвэр, журмаар тогтоосон нээлттэй хувьцаат компанид холбогдох заалтууд болон үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Тахько (ХК) компани 2020 онд компанийн засаглалын зарчим, үйл ажиллагааг хэрэгжүүлж Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 12 дугаар зүйлийн 12.1-ийн 12.1.1-12.1.4, 12.2-ын 12.2.1-12.2.4 дэх хэсэгт заасан үнэт цаас гаргагч болон үнэт цаасны шалгуур (тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргах, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй аудитын байгууллагаар баталгаажуулах, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капиталтай байх эсхүл 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан, компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг, компанийн зах зээлийн үнэлгээ, гаргасан үнэт цаасны нийтэд санал болгосон хувь, компани нь засаглалын болон мэдээллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг)-ын дагуу хоёрдугаар ангиллын нээлттэй компанийн шаардлагыг хангаж байна.

Компанийн бүтэц, зохион байгуулалт

Компани 2020 онд Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Захиргааны болон Техник үйлчилгээний алба, Анкор төв гэсэн бүтэцтэй ажилласан.

Компанийн 2020 онд мөрдөх орон тоо, албан тушаалтны үндсэн цалингийн хэмжээг Гүйцэтгэх захирлын 2020.03.30-ны өдрийн 15 дугаар тушаалаар баталж, байнгын ажлын байрны 27 орон тоо (ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга ороод)-той ажиллахаар төлөвлөж, 26 орон тоо (Анкор төвийн үйлчлэгчийн орон тоонд хүн ажиллуулаагүй)-той ажилласан.

Ажилтнуудтай байгуулсан Хөдөлмөрийн гэрээгээр тохиролцсон ажлын байрны үндсэн цалингийн хэмжээг мөрдөж, тэдний ажлын үр дүнг харгалзан Гүйцэтгэх захирлын 2016 оны 16 тоот тушаалаар баталсан Цалингийн урамшуулал олгох журмын дагуу улиралд нэг удаа үндсэн цалингийн 40 хүртэл хувийн урамшуулал олгож байна. 2020 онд ажилтнууд, удирдлага, ТУЗ-ын гишүүдийн цалин урамшуулалд нийтдээ 923,939.7 мянган төгрөг олгож, цалингийн зардал компанийн нийт зардлын 35.5 хувь болсон.

Компанийн 2019 оны санхүүгийн тайланг “А” форматаар болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргаж, Прайсуотерхаускуперс аудит ХХК-аар олон улсын түвшний аудитын баталгаажуулалт хийлгэж, Төлөөлөн удирдах зөвлөл болон 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулж, дүгнэлт тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын

хөрөнгийн биржид хүргүүлсэн.

Компани, Компанийн дүрмээр олгосон эрх хэмжээний хүрээнд өмч хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой хангамжийн материал, сэлбэг хэрэгслэл, түлш шатахуун худалдан авах, хөрөнгийн их болон урсгал засвар хийх, үйлчилгээ үзүүлэх зэрэг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 66 гэрээ байгуулж, тэдгээр гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, ажлын үр дүнг хүлээн авч, төлбөр тооцоог хийж дуусгасан.

Мобиком корпораци ХХК түрээс, үйлчилгээ, талбай ашиглах гэрээнүүдийг Ньюком проперти ХХК-иар дамжуулан түрээслэх болсон тул 2014 онд байгуулсан тэдгээр гэрээнүүдийг цуцалж, өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлөөр Ньюком проперти ХХК-тай 5 жилийн хугацаагаар тус тус шинээр байгуулсан.

Компанийн өмч хөрөнгийг эрсдэлээс хамгаалах зорилгоор Практикал даатгал компанитай үл хөдлөх хөрөнгийн даатгалын гэрээ шинээр байгуулж, бүх төрлийн даатгалын гэрээнүүдийн дагуу 2020 оны даатгалын хураамжинд 11,212.2 мянган төгрөг төлсөн.

Оёдлын үйлдвэр, компаниас өндөр насны тэтгэвэрт гарсан Хөдөлмөрийн баатар, гавьяат ажилтан болон өндөр настай 320 ахмад настанд цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлж, ахмад настан Хөдөлмөрийн баатар 2 хүнд, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан 1 хүнд, гачигдал тохиолдсон ахмад настан 1 хүнд нийтдээ 14,433.3 мянган төгрөгийн буцалтгүй тэтгэмж, тусламж олгосон байна.

Хүний нөөц, нийгмийн хариуцлагын асуудал

Компани тайлангийн хугацаанд 26 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, байнгын ажлын байрны 21 ажилтны Хөдөлмөрийн болон эд хөрөнгийн бүрэн хариуцлагын, нууц хадгалах гэрээнүүдийн 2019 оны биелэлтийг дүгнэж, уг гэрээнүүдийг үргэлжлүүлэн мөрдөж, Компани Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн ажил олгогчийн үүргээ биелүүлэн ажиллаж байна.

Өөрийнх нь хүсэлтээр хоёр, хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан нэг хүний хөдөлмөрийн гэрээг цуцлан ажлаас чөлөөлж, шинээр нэг хүнийг хүний нөөцийн менежерээр, нэг хүнийг Анкор төвийн менежерээр, нэг хүнийг цахилгаанчнаар тус тус ажилд авч ажиллуулсан.

Нийт ажилтнуудын ажлыг Хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтын чиг үүргийн дагуу улирал тутам дүгнэж, 2020 онд ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн ажил үүрэг, хөдөлмөрийн гэрээ, дотоод журмын зарим заалтыг бүрэн биелүүлээгүй гэж үзсэн 3 ажилтан (нэг цахилгаанчин, нэг засварчин, нэг үйлчлэгч)-ны цалингийн урамшууллыг 5-10 хувиар хасч ажлын хариуцлагыг дээшлүүлэх хөшүүрэг болгон ажилласан.

Хүний нөөцийн ажлын хүрээнд компанийн хөдөлмөрийн харилцааны практик ажиллагаа болон мөрдөж байгаа баримт бичгүүдийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцэж буй эсэх болон хууль зүйн эрсдэлийг тодорхойлуулж, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, зарим шаардлагатай баримт бичгүүдийг өөрчлөх, шинэчлэн боловсруулах ажлыг зөвлөх үйлчилгээний Прайсвотэрхаускүүпэрс Такс ТМЗ ХХК-тай гэрээ байгуулж хамтран хийж гүйцэтгэсэн.

Гүйцэтгэх удирдлагыг удирдлагын коучинг, гүйцэтгэлийн удирдлага, манлайллын, Ерөнхий нягтлан бодогчийг мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрх болон татварын итгэмжлэгдсэн мэргэшсэн зөвлөхийн эрх олгох, Захиргааны албаны менежерийг компанийн засаглалын, эрчим хүчний хэмнэлтийн ажил хариуцсан менежерийг эрчим хүчний менежерийн эрх олгох сургалтад тус тус суралцуулсан. Анкор төвийн менежер, цахилгаанчин, сантехникийн засварчдын мэргэжлийн тасралтгүй болон аюулгүй ажиллагааны эрхийн сургалтууд коронавирусын цар тахлын бүх нийтийн ба өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдон тус тус цуцлагдсан.

Өмнөх онд сургалтын төлбөрүүд нь төлөгдсөн Захиргааны албаны менежер нэг хүн Удирдлагын академид суралцаж бизнесийн удирдлагын магистрийн боловсрол эзэмшсэн, Барилгын салбарын мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох эцсийн шатны сургалтуудад суралцсан Техник үйлчилгээний албаны дарга, цахилгааны инженер нь барилга байгууламжийн цахилгаан хангамжийн угсралт, засварын зөвлөх инженер, Сантехникийн инженер нэг хүн нь барилга, байгууламжийн ус хангамж, ариутгах татуургын системийн угсралт, засварын зөвлөх инженер болж, эрчим хүчний хэмнэлтийн ажил хариуцсан цахилгаанчин нэг хүн эрчим хүчний хэмнэлтийн менежерийн эрхтэй болсон.

Компанийн 4 ажилтанд нийт 90,888.9 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгож ахуй амьдралд нь туслалцаа, дэмжлэг үзүүлсэн.

Коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр гамшгаас хамгаалах Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж хөл хорио тогтоосон хугацаанд ажилдаа ирээгүй ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтын дагуу 8,840.5 мянган төгрөгийн олговор олгосон.

Мөн Засгийн газрын 2020 оны 140 дугаар тогтоолын дагуу 2020 онд компанийн нийт ажиллагсадад нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтөөр нийгмийн даатгалын шимтгэл төлөх дүнгээс 39,968.7 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татвар төлөх дүнгээс 57,465.6 мянган төгрөг олгосон. Компани 71,807.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс чөлөөлөгдсөн байна.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нутаг дэвсгэрийн төр, захиргаа, онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагаас өмчлөгч-ерөнхий түрээсэлэгчийн хувьд Тахько компанид тавьж буй шаардлагын дагуу МА-I, МА-II, U-I барилгуудыг түрээсээр эзэмшиж байгаа Мобиком корпораци, Ньюком проперти, Скайтел ХХК-

дад ковид-19 өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ариутгал халдваргүйжилтийн ажил хийх, иргэд, үйлчлүүлэгчдийг нэвтрүүлэх талаар өгч байгаа журам зааврыг хэрэгжүүлж ажиллах талаар мэдэгдэл шаардлага өгөх, хяналт тавих зэргээр өдөр тутмын зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж ирсэн.

Компанийн ажилтнуудыг цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор компанийн оффис, анкор төв, цахилгаан, дулааны үзель, ээлжийн цахилаанчин, сантехникчдийн өрөө, гарааш, агуулахын байруудад мэргэжлийн байгууллагаар 4 удаа ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж, ажилтнуудыг нэг удаагийн ам, нүүрний хаалт, бээлий, гар ариутгагчаар хангаж, шаардлагатай үед хэрэглэх халат, комбинезон, эм, ариутгалын бодис, амны хаалт, бээлийний нөөц бэлтгэсэн.

Ажилтнуудыг ажилд ирэхэд нь халууныг үзэж бүртгэх, ажлын цагаар гадуур явж ажилласан болон гаднаас ирж ажилласан хүмүүсийн бүртгэл хөтөлж, QR код уншуулдаг болсон.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн ба өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж хөл хорио тогтоосон хугацаанд Скайтел ХХК-ийн түрээсээр эзэмшдэг МА-I барилга (Скайтел үйлчилгээний төв)-ын 2 дугаар давхрын түрээсийн сарын төлбөрийг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс мөн оны 05 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 15 хувийн, 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл 100 хувийн, Ньюком проперти ХХК-ийн түрээсээр эзэмшдэг МА-II барилга (ТЕДИ төв)-ын 2, 3, 4 дүгээр давхрын түрээсийн сарын төлбөрийг 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөн оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд 15 хувийн, 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл 100 хувийн хөнгөлөлт үзүүлсэн.

Нийтдээ 210,400.1 мянган төгрөгийг түрээсийн төлбөрөөс чөлөөлж, хөнгөлсөн.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Тахько (ХК) компанийн тулгын чулуу байгууллагуудын 60 жилийн түүхэнд холбогдох 1937-1997 онуудын архивын баримтаар богино хэмжээний баримтат гэрэл зургийн альбом, видео кино бүтээх ажлыг өөрийн санаачлагаар хийж байгаа компанийн ахмад ажилтанд 3,888.8, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж байгаа эко аялал жуулчлалыг хөгжүүлэх ажилд оролцож хамтран ажиллах зорилгоор, Нийгмийн хөгжил бидний ирээдүй ТББ-д 50,000.0, Нэгдсэн үндэстний загвар байгууллага ТББ-д 5,000.0, Улсын Онцгой байдлын комисст 10,000.0 мянган төгрөгийн хандив тус тус олгосон.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

Компанийн орлого нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр

Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор бүх төрлийн хог хаягдал, нүүрснээс шингэн түлш болон цахилгаан гаргаж авах төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг үргэлжлүүлэн:

Төслийн ажилд шаардлагатай тусгай зөвшөөрлүүдийн судалгаа хийх, холбогдох материалуудыг бэлтгэх ажлуудыг хийж байна.

Улс орны хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон, улсын хилээр гарах орох хөдөлгөөнийг хязгаарласан, зарим байгууллагын үйл ажиллагаа зогссон тул компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх (төслийн ажлын хүрээнд төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл худалдан авч бэлтгэх, туршилтын ажиллагааг эхлүүлэх, ирээдүйн хөгжлийн зураг төсөл, судалгаа хийх, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авах) талаар төлөвлөсөн ажлууд хийгдээгүй болно.

Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр

Их засварын ажил

Гурвалжин дахь агуулахын барилгыг төвийн нэгдсэн цэвэр бохир усны болон дулааны эрчим хүчинд холбох техникийн нөхцлүүдийг холбогдох байгууллагуудаар гаргуулан авч, уг нөхцлийн дагуу барилгын гаднах дулаан, усан хангамж, ариутгах татуурга, барилгын доторх халаалт, цэвэр бохир усны шугам сүлжээний зураг төслийг хийлгүүлж, мэргэжлийн байгууллагаар батлуулсан.

Мөн барилгын цэвэр бохир ус, дулааны гаднах шугамыг бусдын газраар татах талаар Атибус ХХК-тай гэрээ байгуулж, зөвшөөрөл авсан.

Мөн агуулахын барилгын дулаан, цэвэр бохир усны гаднах болон доторх шугам сүлжээний угсралтын ажлыг "Ти Си Би" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн.

Энэхүү их засварын ажлыг нийтдээ 414,295.7 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгэсэн.

Урсгал засварын ажил

U-I барилгын цонх солих, MA-I барилгын дэргэдэх автомашины гараашийн засвар, мөн барилгад ус цэвэршүүлэх төхөөрөмж угсрах, Анкор төвийн барилгын гаднах засвар, автомашины зогсоолуудад автомат хаалт хийх, Гүнт дэх газрын хашаа сунгах, хүлэмж барих, түүний дагалдах ажил, компанийн барилга

хоорондын талбай, явган замын засвар, Анкор төвийн тайзны гэрэлтүүлгийн удирдлагын программ, төхөөрөмж солих, Гүнт дэх газарт цахилгааны техникийн нөхцөл авах, МА-I барилгын цайны өрөөний гэрэлтүүлэг солих, мөн байрны болон түүний дэргэдэх гараашийн гэрэлтүүлгийн засвар, ХПТ-477 дэд өртөөний графикт засвар, зарим барилгын цахилгааны самбар шинэчлэх, МА-I, МА-II, МА-III. U-I барилгуудын халаалтын системийн угаалга, тэдгээрийн сантехникийн засвар, МА-I ба U-I барилгын усны тоолуур солих, траншейны ус соруулах, бохирын худаг угаах, засварлах, дулааны узелийн өргөлтийн насосны засвар, 1 ба 2 дугаар контурын ялтсан бойлеруудыг угаах, шахалт хийх зэрэг 85,967.7 мянган төгрөг (үүнээс 39,001.0 мянган төгрөгийн барилгын, 8,865.4 мянган төгрөгийн цахилгааны, 38,101.3 мянган төгрөгийн сантехникийн)-ийн урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн байна.

Хэвийн үйл ажиллагааг хангах өдөр тутмын ажил

Цахилгаан эрчим хүчний гадаад, дотоод тооцооны нийт 50 гаруй тоолуурын заалтаар цахилгаан эрчим хүчний хэрэглээний тооцоог тогтмол хийж, 254,202.9 мянган төгрөгийн цахилгаан эрчим хүчний үнийг хэрэглэгчдэд хувиарлан төлүүлсэн. Үүнд: цахилгаан 201,209.9, цахилгааны тоолуурын зөрүү 35,613.2, тарифийн зөрүү 11,446.8, үйлчилгээний үнэ 5,933.0 мянган төгрөгийг хэрэглэгчдэд хуваарилж төлбөрийг хийлгэсэн.

Дулааны төлбөрт 53,922.9, үйлчилгээний төлбөрт 1,250.8, цэвэр бохир усны үйлчилгээний төлбөрт 465.1, усны төлбөрт 23,681.4, телефон ярианы төлбөрт 104.4 мянган төгрөгийг хэрэглэгчид хуваарилан төлүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, элэгдэл хорогдлын шимтгэл, сэлбэг, аж ахуй, барилга, хангамж, шатах тослох материал, кассын тооцоонд хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хийлгэж, тайлан бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж ажилласанаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй, бэлэн мөнгөний зарцуулалт, түүнд тавих хяналт хэвшсэн болно.

Ажлын байр, ажиллах нөхцөлийг хангах болон бусад

Ажлын нөхцөлийг хангах зорилгоор 76,603.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (Суурин болон зөөврийн компьютер, телевизор, сервер ба оффисийн лиценз, онлайн төхөөрөмж, оффис болон Анкор төвийн тавилга, зөөврийн цахилгаан үүсгүүр, контейнер), 38,132.0 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авч бэлтгэсэн.

Компанийн оффисын болон мэдээллийн системийн хэвийн сааталгүй ажиллагааг хангах зорилгоор Ай Ти аутсорсинг ХХК-тай гэрээгээр хамтран ажиллаж, интернет, компьютерын болон камерын төхөөрөмж, Wireless access point төхөөрөмж, Unifi controller серверийн өдөр тутмын үйлчилгээ хийлгэн ажиллаж байна. Компанийн сервер, компьютерүүдийн касперски антивирусын программын лицензийг сунгах, Windows сервер болон бүх

компьютерийн үйлдлийн систем, оффисын программуудыг лицензтэй болгох, сүлжээнд firewall төхөөрөмж суурилуулах, тэдгээрийн найдвартай ажиллагааг хангах зэрэг сүлжээний тоног төхөөрөмжийн засварын ажлыг 13,268.5 мянган төгрөгийн зардлаар хийж гүйцэтгэсэн.

Компанийн санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын, хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээврийн хэрэгслийн, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог тогтоосон хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд харилцдаг санхүү, татвар, нийгмийн даатгалын байгууллагад тушааж, 2020 онд улсын төсөвт 49,178.4 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, 70,441.9 мянган төгрөг (үүнээс 40,463.8 нь компаниас, 29,978.1 нь даатгуулагчаас)-ийн нийгмийн даатгалын шимтгэл, 51,461.9 мянган төгрөг (ажиллагсдаас суутгасан 39,118.8, ногдол ашгаас суутгасан 12,343.1 мянган төгрөг)-ийн хувь хүний орлогын албан татвар, 44,902.5 мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, газар, тээврийн хэрэгслийн албан татвар, 202,243.5 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлж, улсын төсөвт төлөх төлбөрийн 93.5 хувийг тайлангийн хугацаанд барагдуулсан байна.

Компани 2020 онд 3,144,469.4 мянган төгрөгийн орлоготой, 2,604,780.1 мянган төгрөгийн зарлагатай, 660,304.5 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, 2019 оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн орлого 405,980.2 мянган төгрөг буюу 11.4 хувиар буурч, зардал 342,724.5 мянган төгрөг буюу 11.6 хувиар буурч, хуримтлагдсан ашиг 5,368,905.7 мянган төгрөг болж 11 хувиар өссөн байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЗАХИРГААНЫ АЛБАНЫ ДАРГА



Л.ЭНХНАСАН

Ц.ДОРЖГОТОВ